

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар сарын ...-
ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төмөр замын тээврийн үндсэн зарчим, үйл ажиллагаа ба төмөр замын объект, эдгээрт тавих нийтлэг шаардлагыг тодорхойлж, төмөр замын байгууламж, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах, галт тэргээр зорчигч, ачаа тээвэрлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, төмөр замын тээврийн үйл ажиллагаанд төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой төр, иргэн, хуулийн этгээдийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж

- 2.1. Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 2.2 Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

- 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- 3.1.1 "төмөр замын тээвэр" гэж төмөр замаар хөдлөх бүрэлдэхүүн ашиглан зорчигч, ачаа тээвэрлэх тээврийн төрлийг;
- 3.1.2 "төмөр замын чиглэл" гэж төмөр замын эхлэх, дайран өнгөрөх, төгсөх цэгийг ерөнхийлөн заасан замналыг;
- 3.1.3 "төмөр замын чиг" гэж энэ хуулийн 3.1.2-т заасан замналын дагуу барих техник, эдийн засгийн Зураг төслийн үндэслэлээр нарийвчлан тодорхойлсон төмөр замын шугамыг;

- 3.1.4 "төмөр замын зурвас газар" гэж төмөр замын чигийн дагуу технологийн үйл ажиллагаа явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалттай газрыг;
- 3.1.5 "төмөр замын суурь бүтэц" /цаашид "суурь бүтэц" гэх/ төмөр зам, түүний технологийн хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүч, ус хангамж, дохиолол, холбоо, холбоо, мэдээллийн барилга байгууламж ба төхөөрөмж, өртөө түүний технологийн хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүч, ус хангамж, дохиолол,
- 3.1.6 "Нийтийн хэрэглээний төмөр замын суурь бүтэц" /цаашид "Нийтийн хэрэглээний суурь бүтэц" гэх/ гэж Монгол Улсын нийслэл, аймгийн төв, хилийн боомт, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газартай холбогдсон гол замын суурь бүтцийг;
- 3.1.7 "Дагнасан хэрэглээний төмөр замын суурь бүтэц" /цаашид "Дагнасан хэрэглээний суурь бүтэц" гэх/ гэж эзэмшигчийн хэрэгцээг хангах, эсхүл гэрээний үндсэн дээр хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх энэ хуулийн 3.1.6-д зааснаас бусад гол замын суурь бүтцийг;
- 3.1.8 "суурь бүтэц эзэмшигч" гэж өмчлөл буюу эзэмшилдээ байгаа энэ хуулийн 3.1.6, 3.1.7-д заасан суурь бүтцийг ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;
- 3.1.9 "гол зам" гэж галт тэргээр зорчигч, ачаа тээвэрлэж, улсын эдийн засаг, нийгмийн хэрэгцээг хангах төмөр замын үндсэн шугамыг;
- 3.1.10 "салбар зам" гэж гол ба өртөөний замаас салбарлаж тавьсан, ачаа ачих, буулгах, ялгах, сэлгээний хөдөлгөөн хийх, гол замын үйл ажиллагааг дэмжих зориулалттай төмөр замын туслах шугамыг;
- 3.1.11 "Дагнасан хэрэглээний зам, талбай" /цаашид Дагнасан хэрэглээний зам, талбай гэх/ гэж ачаа ачих, буулгах, ялгах, хадгалах, сэлгээний хөдөлгөөн хийх зориулалтаар эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах, эсхүл гэрээний үндсэн дээр хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх салбар зам, механикжсан талбайг;
- 3.1.12 "Дагнасан хэрэглээний хэрэглээний зам, талбай эзэмшигч" /цаашид "Дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч" гэх/ гэж төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлага хангасныг нотлох энэ хуульд заасан тохирлын гэрчилгээтэй салбар зам, механикжсан талбайг өмчлөх буюу эзэмших эрхтэй хуулийн этгээдийг;
- 3.1.13 "төмөр замын тээврийн үйл ажиллагаа" гэж энэ хуулийн 23.2-т заасан, талуудын харилцан уялдаатай үйлдвэрлэл-технологийн цогцолбор ажил, үйлчилгээг;

- 3.1.14 "төмөр замын тээврийн байгууллага" гэж суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийг;
- 3.1.15 "төмөр замын тээвэрлэгч" /цаашид "тээвэрлэгч" гэх/ гэж төмөр замын тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;
- 3.1.16 "тээвэрлүүлэгч" гэж зорчигч, ачаа илгээгч ба хүлээн авагч, тээвэр зуучлагчийг;
- 3.1.17 "зуучлагч" гэж тээвэр зуучлалын гэрээний үндсэн дээр тээврийн хөлс төлөгчөөр тээврийн баримт бичигт заагдсан тээвэр зохион байгуулалтын ажил, үйлчилгээ үзүүлж буй этгээдийг хэлнэ.
- 3.1.18 "төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн" /цаашид "хөдлөх бүрэлдэхүүн" гэх/ гэж зүтгүүр, вагон, төмөр замаар явдаг бусад техникийг;
- 3.1.19 "галт тэрэг" гэж төмөр замын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхээр нэг бүрэлдэхүүн болгон найруулж холбосон ажиллагаатай зүтгүүр, вагоны бүрдлийг;
- 3.1.20 "хөдлөх бүрэлдэхүүн зуучлагч" гэж Монгол улсад, эсхүл гадаад улсад бүртгэлтэй хөдлөх бүрэлдэхүүнийг гэрээний үндсэн дээр Монгол улсын нутаг дэвсгэрээр төмөр замын тээвэрт зуучлагч хуулийн этгээдийг;
- 3.1.21 "төмөр замын тээврийн үйл ажиллагаанд мөрдөх тариф" гэж энэ хуульд заасан ажил, үйлчилгээний зарласан үнийг;
- 3.1.22 "төмөр замын аюултай бүс" гэж галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг дэвсгэр газрыг;
- 3.1.23 "төмөр замын аюулгүйн бүс" гэж төмөр замын сүйрэл, ослын болзошгүй аюулаас сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай газрыг;
- 3.1.24 "төмөр замын тээврийн аюулгүй байдал" гэж төмөр замын тээврийн үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, төмөр замын объектод хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх, түүнд учирч болзошгүй аюулаас хамгаалахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг;
- 3.1.25 "хөдөлгөөний нэгдсэн зурмаг" гэж төмөр замын нийт сүлжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг;
- 3.1.26 "суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг" гэж хөдөлгөөний нэгдсэн зурмагт нийцүүлэн суурь бүтэц эзэмшигчийн баталсан тухайн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг;
- 3.1.27 "төмөр замын гарам" гэж авто болон явган хүний замтай нэг түвшинд огтлолцсон төмөр замын уулзварыг;

3.1.28 “хатуу тооцоот багаж, хэрэгсэл” гэж ашиглах, хүлээлцэх ажиллагааг тусгай журмаар зохицуулдаг, хяналт, бүртгэлгүйгээр ашиглахад төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц төмөр замын засвар, үйлчилгээний багаж, хэрэгслийг;

3.2 Төмөр замын нэр томъёоны тайлбарыг энэ хуульд өөрөөр заагаагүй бол төмөр замын нэр томъёоны үндэсний стандартад заасныг баримтална.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна.

4.2. Метро болон түүнтэй адилтгах төмөр замын бусад тээврийн үйл ажиллагааг Засгийн газраас баталсан тусгай дүрмээр зохицуулж болно.

5 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үндсэн зарчим

5.1 Төмөр замын тээврийн бодлогод төрийн бодлогын нэгдмэл уялдааг хангах;

5.2 Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын залгамж чанарыг хадгалах;

5.3 Зурмагийн нэгдмэл зохицуулалттай байх;

5.4 Байнгын хяналттай байх;

5.5 Үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах;

5.6 Тасралтгүй үйл ажиллагааг хангах;

5.7 Зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлөөр хангах;

5.8 Тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулсан байх.

6 дугаар зүйл. Төмөр замын тээврийн бодлого, төлөвлөлт

6.1. Төмөр замын сүлжээг байгуулахдаа Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэнэ.

6.2. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан, хугацаатайгаар хэрэгжүүлнэ.

6.3. Төмөр замын чиглэл, царигийг төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоор тодорхойлно.

6.4. Шинээр барих төмөр замын чигийг Засгийн газар тогтооно.

6.5. Энэ хуулийн 6.2-т заасан бодлогод нийцсэн төмөр замын хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөтэй байна.

7 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тариф, хөлс

7.1. Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд мөрдөх тарифыг Өрсөлдөөний тухай хууль, энэ хуульд нийцүүлэн эрх бүхий этгээд тогтооно.

7.2. Монгол Улсын төмөр замын олон улсын тээврийн тарифыг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн тогтооно.

7.3. Тарифын өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн талаарх төрийн зохицуулалт

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1. Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1 төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого тодорхойлох;

8.1.2 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

8.1.3 төмөр замын тээврийн тухай олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх.

8.1.4 хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

9.1. Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

9.1.2 төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах;

9.1.3 төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм, төмөр замын барилгын ажлын дүрэм,

9.1.4 төмөр замын тээврийн улсын хяналтын дүрэм батлах;

9.1.5 төмөр замын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журмыг батлах

9.1.6 төмөр замын суурь бүтцийн ангилал тогтоох, өөрчлөх;

9.1.7 төмөр замын суурь бүтэц барих төсөл хэрэгжүүлэх эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах;

9.1.8 төмөр замын зурвас газрын хэмжээ, ашиглуулах хугацаа, нөхцөлийг тогтоох;

9.1.9 суурь бүтэц эзэмшигчид төмөр замын зурвас газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэх;

9.2. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1 Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

10.1.2 Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг батлах;

10.1.3 төмөр замын норм, нормативын баримт бичиг /цаашид “норм, нормативын баримт бичиг” гэх/ боловсруулах сан бүрдүүлэх, зарцуулалтыг зохицуулах журам батлах;

10.1.4 төмөр замын зурвас газрын суурь үнэлгээний саналыг Засгийн газарт оруулах;

10.1.5 төмөр замын суурь бүтцийн зураг төслийг хянан шалгаж, дүгнэлт гаргах

10.1.6 төмөр замын суурь бүтцийн чиг тогтоох саналыг, дүгнэлтийн хамт Засгийн газарт оруулна.

10.1.7 төмөр замын мэргэжлийн ажилтан ажиллах албан тушаалын жагсаалт, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалын жагсаалт батлах;

10.1.8 зарим төрлийн /зорчигч, шуудан, улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой ачааны гэх мэт/ тээвэрлэлтэд давуу байдал олгох;

10.1.9 төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

10.1.10 төмөр замын суурь бүтцийг орон нутаг болон олон улсад зарлах;

10.1.11 инженерийн мэргэжлийн орон тооны бус зөвлөл ажиллуулах дүрэм батлах;

10.1.12 төмөр замын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох дүрэм батлах;

10.1.13 хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10.2. Тагнуулын ерөнхий газартай хамтран дараах журмыг батална:

10.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтны зорчих тусгай галт тэрэг аялуулах;

10.2.2. төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачих, буулгах, хадгалах;

10.3. Тусгай ба цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий төрийн байгууллагатай хамтран батална.

10.4. Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд төмөр замын тээврийн хяналтын алба ажиллана.

10.5. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1.6, 10.1.7, 10.2.2, 10.2.3-т заасан бүрэн эрхээс бүрэн буюу хэсэгчлэн төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлж болно.

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

11.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 11.1.1 төмөр замын тээврийн байгууллагатай хамтран зурвас газар, объектод нийгмийн хэв журам сахиулах ажлыг зохион байгуулах;
- 11.1.2 хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой албан тушаалд ээлжээр ажилладаг ажилтныг цэргийн албанд татахаас бусад дайчилгаанд хамруулахгүй байх;
- 11.1.3 гамшгийн улмаас төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагаанд учирсан хор уршгийг арилгахад шаардагдах байгалийн нөөц /түгээмэл тархацтай ашигт малтмал мод, ус зэрэг/-ийг хууль тогтоомжийн дагуу ашиглуулах;
- 11.1.4 гамшгийн хор уршгийг арилгах, аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эзэмшил, ашиглалтад байгаа тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор дайчлах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;
- 11.1.5 энэ хуулийн 36.3-т заасан дэглэмийг төмөр замын тээврийн байгууллагатай хамтран мөрдүүлэх;

12 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

12.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь төмөр замын тээврийн салбарт Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

12.2. Төрийн захиргааны байгууллагын харъяанд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, сургалт, судалгаа эрдэм шинжилгээний байгууллага ажиллана.

12.3. Төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 12.3.1 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;
- 12.3.2 төмөр замын тээврийн салбарт мөрдөх техникийн зохицуулалт, үндэсний стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, мөрдүүлэх;
- 12.3.3 энэ хуулийн 33.1.1-33.1.8-д заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 12.3.4 төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд баталгаажуулалт хийж, тохирлын гэрчилгээ олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 12.3.5 Стандарт, норм нормативын баримт бичиг батлах;
- 12.3.6 төмөр замын суурь бүтцийн нэвтрүүлэх чадвар, тээх ачааны хэмжээ, тариф, тээврийн ажил, үйлчилгээний чанарт хяналт тавьж, санал дүгнэлт гаргах;
- 12.3.7 төмөр замын тээврийн салбар дахь төрийн өмчийн ашиглалт болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд төрийн төлөөллийг олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

12.3.8 улсын хэмжээнд хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

12.3.9 төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, хөтлөх;

12.3.10 хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

12.4. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар, төмөр замын тээврийн салбарын үр ашигтай, тогтвортой хөгжлийг хангах, инноваци, техник, технологийн шинэчлэлтийн бодлогын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэргэжлийн ажиллах хүчнийг сургах, дадлагажуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

13 дугаар зүйл. Төмөр замын тээврийн хяналтын алба, түүний бүрэн эрх

13.1 Төмөр замын тээврийн хяналтын алба /цаашид “хяналтын алба” гэх/ нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарт мэргэжлийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлнэ.

13.2 Хяналтын алба нь төмөр замын тээврийн салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчаас бүрдэнэ.

13.3 Төмөр замын тээврийн салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Улсын ерөнхий байцаагч олгоно.

13.4 Төмөр замын тээврийн салбарын улсын ерөнхий байцаагч нь хяналтын албаны дарга байна.

13.5 Хяналтын алба нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.5.1 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан эрх зүйн бусад актын хэрэгжилтэд хяналт тавих;

13.5.2 төмөр замын объект, төмөр замын тээврийн ажил, үйлчилгээ, технологийн горим нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг өмчийн хэлбэр, байршил харгалзахгүй шалгах;

13.5.3 галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хянаж, сүйрэл, осол, гологдол гарч болзошгүй нөхцөл зохих ёсоор нотлогдсон бол төмөр замын объектын ашиглалтыг хязгаарлах, түр зогсоох;

13.5.4 төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, гологдлын шалтгааныг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах;

- 13.5.5 тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;
 - 13.5.6 хөдлөх бүрэлдэхүүний улсын бүртгэл, дугаарлалт, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;
 - 13.5.7 ачааны жин, тээврийн баримт бичиг, түүнтэй холбогдох бусад мэдээллийг шалгах;
 - 13.5.8 дүрэмт хувцастайгаар албан үүргээ гүйцэтгэх үедээ төмөр замын объектод саадгүй нэвтрэх, галт тэргээр үнэ, төлбөргүй зорчих;
 - 13.5.9 хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
- 13.6 Улсын байцаагч тусгай дүрэмт хувцас хэрэглэнэ.

14 дүгээр. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, түүний чиг, бүрэн эрх, үүрэг

- 14.1 Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв /цаашид “хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/ нь суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах, төмөр замын тээврийн нэгдсэн төлөвлөлтийг хэрэгжүүлж, мэдээллээр хангах чиг үүрэгтэй улсын төсөвт үйлдвэрийн газар байна.
- 14.2 Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын үйл ажиллагаанд баримтлах үндсэн баримт бичиг болно.
- 14.3 Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв нь дараах бүрэн эрхтэй:
- 14.3.1 галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулж батлах гүйцэтгэлд хяналт тавих, зурмагийн тасалдалд шинжилгээ хийх,
 - 14.3.2 суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохион байгуулж, зохицуулалт хийх;
 - 14.3.3 суурь бүтэц хоорондын нэгдсэн технологийн горимыг боловсруулж, батлах;
 - 14.3.4 галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
 - 14.3.5 галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;
 - 14.3.6 хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохицуулах;
 - 14.3.7 хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 14.4 Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв нь дараах үүрэгтэй:
- 14.4.1 галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төвийг төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын инженер мэргэжилтэй, магистраас доошгүй зэрэгтэй, төмөр замын тээвэрлэлт, хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр мэргэшсэн Монгол улсын иргэн удирдана.

14.4.2 галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, ахлах зохицуулагч нь төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын мэргэжилтэй, магистраас доошгүй зэрэгтэй, энэ чиглэлээр 5 доошгүй жил ажилласан Монгол улсын иргэн байна.

15 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын оролцоо

15.1 Төмөр замын төрийн бус байгууллага төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, стандартын хэрэгжилтийг боловсронгуй болгох, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

15.2 Төрийн бус байгууллага нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төмөр замын объект

16 дугаар зүйл. Төмөр замын объект, түүний өмчлөл

16.1 Төмөр замын объектод суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн, төмөр замын бусад байгууламж хамаарна.

16.2 Нийтийн хэрэглээний суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд өмчлөлд байна.

16.3 Энэ хуулийн 16.2-т зааснаас бусад төмөр замын объект өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй болно.

16.4 Төмөр замын онц чухал объект дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад байна. Онц чухал объектын хамгаалалттай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулах ба жагсаалтыг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр батална.

16.5 Төмөр замын объектын засвар, үйлчилгээг энэ хуульд заасан эрх бүхий бусад этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

16.6 Төмөр замын объектын засвар, үйлчилгээтэй холбоотой харилцааг Барилгын тухай хууль, энэ хууль, төмөр замын барилгын ажлын дүрэм, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр зохицуулна.

16.7 Төмөр замын объектын засвар, үйлчилгээг бусдаар гүйцэтгүүлсэн нь тухайн объектын эзэмшигчийг тээврийн аюулгүй байдлыг хангах үүргийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.8 Суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь уг объектын элэгдлийн зардлын хэмжээгээр засварын хуримтлалын сан бүрдүүлэх үүрэгтэй.

17 дугаар зүйл. Төмөр замын объектод тавигдах үндсэн шаардлага

17.1 Төмөр замын объект нь хөдөлгөөний болон техникийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, норм норматив, стандарт, технологийн горимд нийцсэн байна.

17.2 Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасны дагуу тохирлын гэрчилгээ авсан төмөр замын объектыг тээврийн үйл ажиллагаанд ашиглана.

18 дугаар зүйл. Төмөр замын байгууламж

18.1 Төмөр замын байгууламжид дараах инженерийн байгууламжууд хамаарна:

18.1.1 зам, замын хиймэл байгууламж, гарам, хориг хашаа;

18.1.2 Төмөр замын өртөө зөрлөгүүд дээр галт тэрэгний хөдөлгөөнийг удирдаж хянахад ашиглагдах дохиолол, холбооны төхөөрөмж байгууламж;

18.1.3 эрчим хүчний, усны, мэдээлэл, харилцаа холбооны барилга байгууламж, төхөөрөмж;

18.1.4 замын болон хөдлөх бүрэлдэхүүний засвар, үйлчилгээ, оношилогоо, зэхэлт, бэлтгэлийг хангах барилга байгууламж, төхөөрөмж;

18.1.5 ачаа ачих, буулгах, шилжүүлэх зориулалтын зам, талбай, тавцан, агуулах, төхөөрөмж;

18.1.6 төмөр замын техник технологийг хөгжүүлэх, туршин судлах, төмөр замын мэргэжилд сурган дадлагажуулах зориулалтын барилга байгууламж, төхөөрөмж.

18.2 Төмөр замын байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ тус бүрээр аж ахуйн үйл ажиллагааг дагнан эрхэлж болно.

19 дүгээр зүйл. Төмөр замын суурь бүтэц

19.1 Төмөр замын суурь бүтцийг дор дурдсанаар ангилна.

19.1.1 Нийтийн хэрэглээний төмөр замын суурь бүтэц;

19.1.2 Дагнасан хэрэглээний төмөр замын суурь бүтэц.

19.2 Төмөр замын зэрэглэл, түүнд тавигдах шаардлагыг олон улсын стандартад нийцүүлэн үндэсний стандартаар тогтооно.

19.3 Бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос улсын хилийн боомт хүрэх ачаа тээврийн зориулалттай, төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан чиглэлийн төмөр замын суурь бүтцийг энэ хуулийн 16.2-т заасан хуулийн этгээд шинээр барина.

19.4 Өмчлөхөөс бусад онцгой эрхийн нөхцөлөөр энэ хуулийн 19.3-т зааснаас бусад нийтийн хэрэглээний суурь бүтцийг хувийн болон өмчийн олон хэлбэрийн хуулийн этгээд барьж болно. Онцгой эрхтэй холбоотой харилцааг Концессын тухай хуулиар зохицуулна.

20 дугаар зүйл. Дагнасан хэрэглээний зам, талбай

20.1 Дагнасан хэрэглээний зам, талбай дараах шаардлагыг хангана:

20.1.1 суурь бүтцэд тавих засвар үйлчилгээний шаардлагыг нэгэн адил хангах;

20.1.2 Гол ба өртөөний замаас салбарлаж байгаа дагнасан хэрэглээний зам, талбай шинээр барих, өргөтгөх этгээд Төрийн захиргааны төв

байгууллагын шийдвэрлэснээр холбогдох байгууллагаас техникийн нөхцөл авна;

20.1.3 энэ хуулийн 20.1.2-т заасан техникийн нөхцөл нь хөрш залгаа бусад аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд саад учруулахааргүй байх;

20.1.4 Дагнасан хэрэглээний зам эзэмшигч нь давуу байдлаа ашиглан өөрийн замаар дамжин өнгөрөх бусад дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийн зам ашиглалтад саад учруулахгүй байх;

20.2 Дагнасан хэрэглээний замаар ачаа тээвэр дамжин өнгөрүүлэхтэй холбоотой харилцааг эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

20.3 Дагнасан хэрэглээний зам ашиглах тариф тогтооход суурь бүтэц ашиглах тариф тооцох аргачлалыг жишиг болгоно.

20.4 Дагнасан хэрэглээний зам, талбайд зам, талбай, вагон, чингэлэг цэвэрлэх угаах, ариутгах, бусад зориулалтын байгууламж шинээр барих, төхөөрөмж суурилуулах бол салбарласан гол ба өртөөний замын суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцөнө.

21 дүгээр зүйл. Хөдлөх бүрэлдэхүүн

21.1 Хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, оношлох, баталгаа олгохтой холбоотой харилцааг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр зохицуулна.

21.2 Хөдлөх бүрэлдэхүүн оношлох, засварлах, засварын чанарыг шалган, баталгаажуулах ажиллагааг ашиг сонирхлын зөрчилгүй тусдаа хуулийн этгээд гүйцэтгэнэ.

21.3 Төмөр замын нийтлэг багц дүрэмд заасан хугацаанд засвар, үйлчилгээ, оношлогоо хийгдээгүй хөдлөх бүрэлдэхүүнийг хөдөлгөөнд оролцуулахгүй.

21.4 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр хөдлөх бүрэлдэхүүний хийцэд өөрчлөлт оруулж болно.

21.5 Хөдлөх бүрэлдэхүүнийг энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр төмөр замын тээврийн хөдөлгөөнд оролцуулахаас татгалзахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төмөр замын барилгын ажил

22 дугаар зүйл. Төмөр замын барилгын ажил

22.1 Төмөр замын барилгын ажилд төмөр замын байгууламж барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах, төмөр замыг цахилгаанжуулах, төхөөрөмж угсрах, суурилуулах ажил хамаарна.

22.2 Төмөр замын барилгын ажлыг Барилгын тухай хууль, энэ хууль, холбогдох хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд гүйцэтгэнэ.

22.3 энэ хуулийн 33.1.6-33.1.8-д заасан барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно.

22.4 Барилгын тухай хууль, энэ хуульд өөрөөр заагаагүй бол төмөр замын барилгын ажилтай холбоотой харилцааг төмөр замын барилгын ажлын дүрмээр зохицуулна.

22.5 Төмөр замын барилгын ажлыг хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

22.6 Төмөр замын барилгын ажилд тухайн орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллага дэмжлэг үзүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн үйл ажиллагаа

23 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үйл ажиллагаа

23.1 Төмөр замын тээврийн тогтолцоо нь улсын эдийн засаг, нийгмийн хэрэгцээт тээврийг тусгайлан бүтээсэн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн ашиглан, цаг хугацаа, орон зай, чиглэлийн хязгаарлагдмал орчинд нарийн төлөвлөсөн зурмагаар зохицуулан зохион байгуулдаг үйлдвэрлэл-технологийн цогцолбор үйл ажиллагаанаас бүрдэнэ.

23.2 Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд дараах ажил, үйлчилгээ хамаарна:

23.2.1 тээвэрлэлтийн үйлчилгээ;

23.2.2 суурь бүтэц ашиглах, ашиглуулах үйлчилгээ;

23.2.3 хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт,

23.2.4 тээврийн бусад ажил, үйлчилгээ.

23.3 Тээврийн үйл ажиллагааг Иргэний хууль, энэ хууль, Төмөр замаар зорчигч, ачаа тэвэрлэх дүрэм, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр зохицуулна.

23.4 Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын тээврийн хамтын хариуцлагатай холбоотой харилцааг төмөр замаар зорчигч, ачаа тэвэрлэх дүрмээр зохицуулна.

23.5 Тээврийн үйл ажиллагаанд оролцогч нь төмөр замын тээврийн ажил, үйлчилгээний технологийн горимыг төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, холбогдох стандарт, дүрэм, журамд нийцүүлэн баталж, мөрдүүлнэ.

24 дүгээр зүйл. Суурь бүтэц ашиглах, ашиглуулах үйлчилгээ

24.1 Суурь бүтэц эзэмшигч нь энэ хуульд заасан гэрээний үндсэн дээр тээвэрлэгчид үйлчилгээ үзүүлнэ.

24.2 Суурь бүтэц эзэмшигч тухайн төмөр замын нэвтрүүлэх хүчин чадал хэтэрсэнээс бусад үндэслэлээр тээвэрлэгчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

24.3 Засгийн газар ачаа тээврийн нэгдсэн бодлоготой уялдуулан шаардлагатай тохиолдолд суурь бүтэц эзэмшигчийн саналыг үндэслэн тээвэрлэгчийн тухайн суурь бүтцээр нэвтрүүлэх тээврийн хэмжээнд хувь тогтоож болно.

24.4 Суурь бүтэц эзэмшигч энэ хуулийн 24.3-т заасан хувь хэмжээг мөрдөх үүрэгтэй.

25 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйлчилгээ

25.1 Төмөр замын тээвэрлэлтийн үйлчилгээнд зорчих тасалбарын дагуу зорчигчийг хүрэх өртөөнд хүргэх, ачааг тээврийн баримт бичгийн дагуу тээвэрлэлтэд хүлээн авсан үеэс хүлээлгэн өгөх хүртэлх цогцолбор ажил, үйлчилгээ хамаарна.

25.2 Олон улсын тээвэрт олон улсын тээврийн баримт бичгийг, орон нутгийн тээвэрт төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан тээврийн баримт бичгийн загварыг мөрдөнө.

25.3 Тээвэрлэгч гэрээний үндсэн дээр тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлнэ. Зорчих тасалбар, пайзыг зорчигчид гардуулснаар зорчигч тээвэрлэлтийн гэрээ, тээврийн баримт бичгийг үйлдэн ачаа илгээгч буюу түүний зуучлагчид гардуулсанаар ачаа тээврийн гэрээ байгуулагдсан гэж үзнэ.

25.4 Тээвэрлэлт, тээвэрлэлтийн явц дахь өөр царигийн хоорондох шилжүүлэн ачилтыг гэрээний үндсэн дээр бусад тээвэрлэгч гүйцэтгэж болно.

26 дугаар зүйл. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт

26.1 Төмөр замын объектод тавих үндсэн шаардлага хангасан зүтгүүрийг энэ хуулийн 33.1.2-т заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хөдөлгөөний зурмагийн дагуу ашиглана.

26.2 Хөдлөх бүрэлдэхүүний зах зээлийн эрэлтийг эхний ээлжинд Монгол Улсад бүртгэлтэй бөгөөд энэ хуулийн 17.1-д заасан шаардлага хангасан хөдлөх бүрэлдэхүүнээс нийлүүлнэ.

26.3 Энэ хуулийн 26.2-т заасныг төмөр замын тээврийн байгууллага, хөдлөх бүрэлдэхүүн зуучлагч биелүүлэх үүрэгтэй.

26.4 Гадаад улсад бүртгэлтэй вагоны ашиглалт, засварыг тухайн вагоны зуучлагч хариуцна.

26.5 Гадаад улсад бүртгэлтэй зүтгүүрийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр жолоодлогын баг, бүрэлдэхүүнгүй түрээсэлж болно.

26.6 Хөдлөх бүрэлдэхүүний зуучлал, ашиглалттай холбоотой энэ хууль, холбогдох дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хуульд нийцүүлэн талуудын хооронд байгуулсан гэрээгээр нарийвчлан зохицуулна.

27 дугаар зүйл. Төмөр замын тээврийн бусад ажил, үйлчилгээ

27.1 Төмөр замын тээврийн бусад ажил, үйлчилгээнд төмөр замын тээврийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай энэ хуулийн 24, 25 дугаар зүйлд зааснаас бусад ажил, үйлчилгээ хамаарна.

27.2 Тээврийн бусад ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр төмөр замын тээврийн бус байгууллага гүйцэтгэж болно.

27.3 Төмөр замын тээврийн бусад ажил, үйлчилгээнд тавих шаардлагыг үндэсний стандартаар тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч

28 дугаар зүйл. Тээврийн үйл ажиллагаанд оролцогч, тэдгээрийн нийтлэг эрх, үүрэг

28.1 Энэ хуулийн 23.2-т заасан ажил, үйлчилгээг үзүүлдэг хуулийн этгээдийг тээврийн үйл ажиллагаанд оролцогч гэнэ.

28.2 Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч нь бусад оролцогчидтой энэ хуулийн 32.1.15-д заасны дагуу гэрээ байгуулж, төмөр замын тээврийн ажил, үйлчилгээний уялдааг хангаж ажиллана. Гэрээгээр талуудын үйл ажиллагаа явуулах хүрээг зааглан, хүлээх үүрэг, хариуцлага, хамтын ажиллагааг тодорхойлно.

28.3 Тээврийн үйл ажиллагаанд оролцогч дор дурдсан нийтлэг эрхтэй:

28.3.1 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан шийдвэрийн дагуу төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх;

28.3.2 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, стандартад нийцүүлэн дотооддоо үйлчлэх эрх зүйн акт баталж, мөрдүүлэх;

28.3.3 энэ хуульд нийцүүлэн төмөр замын тээврийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх тариф тогтоох;

28.3.4 хууль тогтоомжид заасан бусад эрх.

28.4 Тээврийн үйл ажиллагаанд оролцогч дор дурдсан нийтлэг үүрэгтэй:

28.4.1 тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй байх;

28.4.2 төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

28.4.3 Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, холбогдох бусад эрх зүйн актыг дагаж мөрдөх;

28.4.4 төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой захирамжлалыг биелүүлэх;

28.4.5 эзэмшиж байгаа төмөр замын объектын тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, тэдгээрийн бүртгэлийг хөтөлж, тогтоосон журам, технологийн дагуу үзлэг, үйлчилгээ хийх;

28.4.6 үйл ажиллагааны орлогын тодорхой хэсгийг төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахад зарцуулах;

28.4.7 Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасны дагуу эрх бүхий төрийн байгууллагад холбогдох мэдээ, тайлан гаргаж өгөх;

28.4.8 хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

28.5 Тээврийн үйл ажиллагаанд оролцогчийн тээврийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Иргэний хууль, төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, холбогдох бусад эрх зүйн актаар зохицуулна.

29 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн байгууллагад тавих нийтлэг шаардлага

29.1 Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч тусдаа хуулийн этгээд байна.

29.2 Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг, тээвэрлэгч нь тээврийн бусад үйл ажиллагааг эрхлэж байгаа бол тэдгээрийн санхүүгийн тооцоо нь тусдаа байна.

29.3 Бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос улсын хилийн боомт хүрэх чиглэлийн ачаа тээврийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч тээвэрлэгч нь төрийн өмчит хуулийн этгээд байна.

29.4 Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний удирдлагын төв нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн сүлжээнд холбогдох нөхцөлийг хангасан байна.

29.5 Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн биелэлт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн дотоод хяналтын нэгжтэй байна.

29.6 Төмөр замын тээврийн байгууллага тээврийн үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран ажиллах, үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно.

29.7 Энэ хуулийн 16.4-т зааснаас бусад объект, ачааны тээврийн хамгаалалтыг гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд заасан эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж болно.

30 дугаар зүйл. Суурь бүтэц эзэмшигчийн эрх, үүрэг

30.1 Суурь бүтэц эзэмшигч нь дараах эрхтэй:

30.1.1 суурь бүтэц ашиглах, ашиглуулах;

30.1.2 суурь бүтэц ашиглуулсны төлбөр, засвар, үйлчилгээний хөлс авах;

30.1.3 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасан шаардлага хангаагүй, хөдөлгөөний аюулгүй байдал зөрчсөн хөдлөх бүрэлдэхүүнийг суурь бүтэц дээгүүр аялуулахаас татгалзах;

30.1.4 өөрийн гол зам, өртөөнөөс салбарлаж тавьсан зам, талбайтай байх;

30.1.5 шинэ суурь бүтэц холбох үед давуу эрх эдлэх;

30.1.6 хууль тогтоомжид заасан бусад эрх.

30.2 Суурь бүтэц эзэмшигч дараах үүрэгтэй:

30.2.1 өөрийн эзэмшлийн суурь бүтцийн хөдөлгөөний болон техникийн аюулгүй байдлыг хангаж, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

30.2.2 хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу өөрийн гол зам дээгүүр галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах, хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх;

30.2.3 холбогдож байгаа суурь бүтцийн эзэмшигчид галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, мэдээлэл солилцоо, эрчим хүчний болон бусад объектын ашиглалт, хөдлөх бүрэлдэхүүний солилцоо, техникийн үйлчилгээг зохицуулсан гэрээ байгуулах;

30.2.4 өөрийн гол ба өртөөний замтай холбогдсон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчтэй гэрээ байгуулж, галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах арга хэмжээ авах;

30.2.5 суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг тогтоосон журмаар нэгдсэн зурмагт нийцүүлэн боловсруулж батлах, хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;

30.2.6 болзошгүй сүйрэл, ослын үед хэрэглэх тусгайлан тоноглогдсон хөдлөх бүрэлдэхүүнтэй байх;

30.2.7 хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

30.3 Суурь бүтэц эзэмшигч өөрийн хараат, охин, зэргэлдээ компани болон хөрөнгө оруулсан тээвэрлэгчтэй суурь бүтэц ашиглалтын гэрээний үнэ, тээвэрлэлтийн хэмжээг бусад тээвэрлэгчээс ялгавартай, давуу нөхцөлөөр байгуулахыг хориглоно.

31 дүгээр зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

31.1 Тээвэрлэгч дараах эрхтэй:

31.1.1 гэрээний дагуу суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай ашиглах, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, ашиглах;

31.1.2 захиалга, гэрээний дагуу өөрөө буюу бусад тээвэрлэгчээр дамжуулан тээвэрлэлтийг гүйцэтгэх;

31.1.3 гэрээгээр тохирсон үйлчилгээний хөлс авах;

31.1.4 хөдлөх бүрэлдэхүүний хүчин чадал, овроос хэтэрсэн, тээвэрлэлтийн хугацааны дотор түргэн муудах ачааг тээвэрлэхээс татгалзах;

31.1.5 ачааг аюулгүй байдлын шаардлага хангах журмын дагуу тээвэрлэлтэд бэлтгээгүй, илгээх үнийг ижил төрлийн барааны зах зээлийн үнээс хэт өндрөөр зарласан, төлбөрийн чадваргүй болсон бол тээвэрлүүлэгчид тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

31.1.6 хууль тогтоомжид заасан бусад эрх.

31.2 Тээвэрлэгч дараах үүрэгтэй:

31.2.1 төмөр замын тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

31.2.2 эзэмшилдээ зүтгүүртэй, эсхүл бусдын эзэмшлийн зүтгүүр ашиглах эрхийг гэрээний үндсэн дээр олж авсан байх;

31.2.3 тээвэрт ашиглаж байгаа хөдлөх бүрэлдэхүүний техникийн аюулгүй байдлыг хангах;

31.2.4 суурь бүтэц эзэмшигчтэй байгуулсан суурь бүтэц ашиглах гэрээний үндсэн дээр тээвэрлүүлэгчид тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх;

31.2.5 өөрийн хараат, охин, зэргэлдээ компани болон ашиг сонирхлын зөрчилтэй этгээдэд тээвэрлэлтийн илүү хөнгөлөлттэй, давуу нөхцөл олгохгүй байх;

31.2.6 хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

31.3 Тээвэрлэгч нь хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд зааснаас бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

31.4 Тээвэрлэгч Иргэний хуульд зааснаас гадна дараах тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө:

31.4.1 ачааны өөрийн байгалийн шинж чанараас шалтгаалж хорогдол гарсан;

31.4.2 хууль, хяналтын байгууллагын шийдвэрээр ачааг хилээр буцаан гаргасан, хилээр нэвтрүүлээгүй, ачааг устгалд оруулсан;

31.4.3 тээвэрлүүлэгчийн буруутай үйлдлээс ачаа гэмтсэн, хорогдсон, устсан;

31.4.4 олон улсын төмөр замын гэрээ, хэлэлцээрт заасан үндэслэлээр.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын үндсэн шаардлага

32 дугаар зүйл. Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм

32.1 Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр дор дурдсан харилцааг зохицуулна:

32.1.1 төмөр замын техник ашиглах;

32.1.2 төмөр замын дохиолол, холбоо ашиглах;

32.1.3 галт тэрэгний хөдөлгөөний удирдах;

- 32.1.4 төмөр замын тээврийн осол, гологдлыг судлан бүртгэх;
- 32.1.5 төмөр замын гүүр, хонгилыг гэмт халдлагаас хамгаалах;
- 32.1.6 төмөр замын тээврийн хөдөлгөөн нээх, хаах;
- 32.1.7 галт тэрэгний хөдөлгөөний зурмаг зохицуулах;
- 32.1.8 суурь бүтэц ашиглах;
- 32.1.9 төмөр замын тээвэрлэлт, суурь бүтэц ашиглуулах, хөдлөх бүрэлдэхүүн ашиглах болон бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамж, тарифийг хэрэглэх аргачлал тогтоох;
- 32.1.10 төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох;
- 32.1.11 төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх;
- 32.1.12 төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх;
- 32.1.13 галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилга, ажлын цагийн хуваарь тогтоох;
- 32.1.14 төмөр замын мэргэжлийн ажилтан бэлтгэх;
- 32.1.15 төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч хоорондын хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загвар, тээврийн баримт бичгийн загвар;
- 32.1.16 төмөр замын тээврийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох;
- 32.1.17 шинээр барих суурь бүтэц болон дагнасан хэрэглээний хэрэглээний замын холболтын байршил тогтоох, холбох, ашиглалтад оруулах;
- 32.1.18 хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, оношилох, ашиглах, устгал хийх;
- 32.1.19 төмөр замын гарам ашиглах;
- 32.1.20 аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох;
- 32.1.21 хатуу тооцоот багаж ашиглах
- 32.1.22 сүйрэл, ослын үед арга хэмжээ авах;
- 32.1.23 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох;
- 32.1.24 суурь бүтэц зарлах
- 32.1.25 Онц чухал объектын жагсаалт.

33 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл

33.1 Төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дор дурдсан төрлөөр, үйл ажиллагаа тус бүрээр олгоно:

33.1.1 суурь бүтэц барих, ашиглах;

33.1.2 тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх;

33.1.3 замын дээд ба доод бүтцийн эд ангийн үйлдвэрлэл эрхлэх;

33.1.4 замын дээд ба доод бүтцийн засварын ажил гүйцэтгэх;

33.1.5 замын дээд ба доод бүтэц, ачилт, буулгалтын механикжсан талбайн барилга угсралт, төмөр зам цахилгаанжуулалтын ажил гүйцэтгэх;

33.1.6 төмөр замын инженерийн байгууламжийг /хиймэл байгууламжийг/ барьж, ашиглах

33.1.7 хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засварын үйл ажиллагаа эрхлэх;

33.1.8 дохиолол, холбооны төхөөрөмж, хэрэгслийн үйлдвэрлэл, байгууламжийн засварын үйл ажиллагаа эрхлэх;

33.1.9 дохиолол, холбоо, галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалт, хяналтын төхөөрөмжийн суурилуулалтын ажил гүйцэтгэх;

33.2 Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцаанд Барилгын тухай хууль, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, энэ хууль хоорондоо зөрчилдвөл энэ хуулийн 33.1.1-33.1.5-д заасан тусгай зөвшөөрлийг энэ хуулиар, 33.1.6-33.1.8-д заасан тусгай зөвшөөрлийг Барилгын тухай хуулиар тус тус нарийвчлан зохицуулсан гэж үзнэ. Холбогдох хуулиар зохицуулаагүй харилцааг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр зохицуулна.

33.3 Төмөр замын суурь бүтэц барих, төсөл хэрэгжүүлэх эрх авах өргөдөл гаргахад дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

33.3.1 зураг, төсөл

33.3.2 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

33.3.3 хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

33.3.4 үйл ажиллагаа эхлэх хугацаа, эзэмшилд байх газрын зааг.

33.3.5 Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангасан эсэх;

33.4 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 33.3-т заасан өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэх үед дараах нөхцөл байдлыг шалгаж, дүгнэлт гаргана:

33.4.1 улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн хэрэглээний эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхолд харшлах нөхцөл байдал байгаа эсэх;

33.4.2 эзэмшилд олгох газар нь улсын тусгай хэрэгцээний бусад газар, бусдын эзэмшлийн газартай давхцаж байгаа эсэх;

33.4.3 байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эсэх;

33.4.4 дотооддоо үйлчлэх техник, технологийн дүрэм, зааврын бүрдлийг хангасан эсэх;

33.4.5 Засгийн газрын үүрэг болгосон холбогдох бусад асуудал.

33.5 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төмөр замын суурь бүтэц барих төсөл хэрэгжүүлэх эрх хүссэн өргөдлийг ажлын 20 өдрийн дотор нягтлан шалгаж, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

33.6 Засгийн газар энэ зүйлийн 33.3-т заасан өргөдлийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 45 өдрийн дотор, Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 33.1.1-33.1.9-д заасан тусгай зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авсанаас хойш ажлын 20 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай бол энэ заалтад заасан хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр сунгана.

33.7 Эрх, тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар зохих шийдвэрийг өргөдөл гаргагчид бичгээр хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн салбар дахь стандартчлал, норм норматив ба хэмжилт

34.1 Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч нь стандарт, норм нормативын баримт бичгийг мөрдөх, хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийлгэх үүрэгтэй.

34.2 Стандарт, норм, нормативын баримт бичиг боловсруулах сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

34.2.1 Төмөр замын зураг төсөл, барилгын ажлын төсөвт өртгийн 0.18 хувиар авсан;

34.2.2 Стандарт, норм, нормативын баримт бичиг боловсруулах, боловсронгуй болгох зориулалтаар өгсөн төмөр замын тээврийн байгууллагын хандивын орлого;

34.2.3 Стандарт, норм, нормативын борлуулалтын орлого.

3.2 Төмөр замын тээврийн салбарт дагаж мөрдөх стандарт, норм, нормативыг энэ хууль, стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжид заасны дагуу боловсруулан батлуулна.

35 дугаар зүйл. Төмөр замын зурвас газар

35.1 Энэ хуулийн 19.1.1-д заасан төмөр замын зурвас газар улсын тусгай хэрэгцээний газар байна.

35.2 Зурвас газрын өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой харилцааг Газрын тухай хуулиар зохицуулна.

36 дугаар зүйл. Аюултай болон аюулгүйн бүс тэдгээрийн дэглэм

36.1 Төмөр замын аюултай бүсийн дэглэм, төмөр замын зурвас газар болон аюулгүйн бүсийн дэглэм, хэмжээг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг харгалзан Засгийн газар тогтооно.

36.2 Төмөр замын зурвас газрын болон аюулгүйн бүсийн дэглэм, хэмжээг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг харгалзан Засгийн газар тогтооно.

36.3 Аюултай бүсийн дэглэмийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

36.4 Төмөр замын зурвас газарт байгаа мод, бут, өвс, ургамал нь тээврийн аюулгүй байдалд саад учруулахаар бол төмөр замын суурь бүтэц эзэмшигч тэдгээрийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох, хадах, түймэр гаргахгүйгээр шатаах зэргээр аюулгүй байдлын нөхцөлийг хангана.

36.5 Төмөр замын зурвас газар, аюултай бүсэд төмөр замын суурь бүтэц эзэмшигч, дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч хаалт, хамгаалалт хийнэ.

36.6 Төмөр замын зурвас газарт энэ хуулийн дагуу тогтоосон дэглэмд зааснаас бусад ажил, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

36.7 Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын зурвас газарт хамаарах сул, чөлөөтэй газрыг газар тариалан, зорчигч үйлчилгээ, шатамхай болон аюултай ачаанаас бусад ачааг хадгалах, буулгах, үйлчилгээ эрхлэх болон бусад зориулалтаар төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлагад чанд нийцүүлэн иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэн ашиглуулж болно.

36.8 Төмөр замын зурвас газар, аюултай болон аюулгүйн бүс нь бусад тусгай дэглэм бүхий газруудтай давхардаж байгаа бол тухайн газарт тэдгээрийн талаар тогтоосон хамгийн хатуу дэглэм үйлчилнэ.

36.9 Төмөр замын зурвас газраас гаднах аюулгүйн бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, аливаа үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга аюулгүй байдлын талаар гаргасан зөвлөмж, дүгнэлтийг харгалзан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн олгоно.

36.10 Төмөр замын зурвас газрыг суурь бүтэц эзэмшигч тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэй ашиглана.

37 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа

37.1 Төмөр замын тээврийн аюулгүй байдал нь төмөр замын болон бусад байгууллага, иргэдийн дараах үйл ажиллагаагаар хангагдана:

37.1.1 зорчигчийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;

37.1.2 хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

37.1.3 ачааг бүрэн бүтэн тээвэрлэх;

37.1.4 төмөр замын байгууллагын ажилтанд тавих аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах;

37.1.5 хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

38 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт

38.1 Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагаар зохицуулна.

38.2 Эрчим хүч нийлүүлэгч нь галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой суурь бүтцийн эрчим хүчний хангалтыг тасалдуулахгүй байх үүрэгтэй.

38.3 Зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт стандарт, норм норматив, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тогтоосон гэрэлтүүлэг, тавцан, талбайтай зориулалтын замаар хүлээн авч явуулна.

38.4 Төмөр замын тээврийн байгууллага, дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь тэмдэг, дугаар бүхий хатуу тооцоот багаж, хэрэгсэлтэй байх бөгөөд түүнийг үйлдвэрлэх, худалдах, ашиглах болон хүлээлцэх журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтоож, жагсаалтыг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлнэ.

38.5 Төмөр замын тээврийн байгууллага, дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь төмөр замын тээврийн үйл ажиллагаанд саад учруулах байгалийн гамшиг, сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгах талаар шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй.

38.6 Хүний амь нас, эрүүл мэнд, ачаа, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдалд хохирол учруулах нөхцөл байдал, байгалийн гамшиг, сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгахад холбогдох төрийн захиргааны болон орон нутгийн эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн туслах үүрэгтэй.

38.7 Хүний амь нас, эрүүл мэнд, ачаа, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдалд хохирол учруулах нөхцөл байдал, байгалийн гамшиг, сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгах ажиллагаанд оролцсон иргэн, аж ахуйн нэгж холбогдон гарсан бодит зардал, учирсан хохирлоо төлүүлэхээр төмөр замын тээврийн байгууллагаас шаардах эрхтэй.

39 дүгээр зүйл. Төмөр замын гармыг ашиглах дэглэм

39.1 Төмөр замын гармыг нээх, ашиглах, хаах, хамгаалалтын дохио, тэмдэг, төхөөрөмжөөр тоноглох, засварлах, түүнчлэн төмөр замын гармын зэрэглэл тогтоох журмыг цагдаагийн байгууллагатай зөвшилцөн батална.

39.2 Төмөр замыг бусад төмөр зам болон авто замтай ижил бус түвшинд огтлолцуулах шийдвэрийг хөдөлгөөний аюулгүй байдал, гармаар нэвтрэх явган зорчигч, автозамын хөдөлгөөний нягтралыг харгалзан зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

39.3 Төмөр замын гармын хэвийн ажиллагаа, ашиглалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг суурь бүтэц эзэмшигч, дагнасан хэрэглээний зам эзэмшигч хариуцна.

39.4 Гинжит машин механизм, овортой ачаа бүхий авто тээврийн хэрэгслийг төмөр замын гармаар гаргахдаа тухайн гармыг хариуцсан суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр түүний томилсон ажилтны хяналтын дор гүйцэтгэнэ.

39.5 Төмөр замыг энэ хуулийн 39.2-т заасны дагуу бусад төмөр зам болон авто замтай ижил бус түвшинд огтлолцуулах бол үүнтэй холбоотой гарах зардлыг шинээр буюу сүүлд зам тавьж байгаа этгээд хүлээнэ.

39.6 Төмөр замын гармын байршлыг тогтоохдоо нутгийн өөрөө удирдах байгууллага, төмөр замын тээврийн байгууллагын саналыг харгалзана.

40 дугаар зүйл. Аюултай ачааны тээвэрлэлт, аюултай байгууламжийн ашиглалт, хамгаалалт

40.1 Аюултай ачааны үйлдвэрлэл, хадгалалт, ачилт, буулгалт, дамжуулалт хийж байгаа газрын барилга байгууламж /цаашид “аюултай байгууламжууд” гэх/ нь суурь бүтцийн аюулгүй ажиллагааг хангахуйц зайд байрлах бөгөөд аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална.

40.2 Аюултай байгууламж эзэмшигч нь түүний аюулгүй ажиллагааг хариуцаж, аюултай байгууламжтай холбоотой осол, гэмтэл гарсан тохиолдолд төмөр замын тээврийн байгууллагад нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

40.3 Аюултай ачааг төмөр замаар тээвэрлэхэд бэлтгэх, ачих, буулгах үеийн аюулгүй байдлыг ачаа илгээгч ба ачаа хүлээн авагч хангана.

40.4 Аюултай ачаа тээвэрлэлтийн үед гарсан осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгахад суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч өөрийн галын болон сэргээн босголтын хэрэгслийг ашиглан оролцох үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөр зохицуулалт, нийгмийн баталгаа

41 дүгээр. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны хөдөлмөрийн нөхцөл

41.1 Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны хөдөлмөр зохицуулалт, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгааг энэ хууль, Хөдөлмөрийн тухай хууль

тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, хамтын болон хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

41.2 Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн зохион байгуулагч, тээвэрлэлтийн үйлчилгээний ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас хэрэглэнэ.

41.3 Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд зохих сургалтад хамрагдаж, тухайн ажлыг гүйцэтгэх эрх авсан, эрүүл мэндийн хувьд тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг ажиллуулна.

41.4 Эрүүл мэндийн үзлэг хийх хугацаа, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

42 дугаар зүйл. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны хөдөлмөрийн сахилга

42.1 Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан хөдөлмөрийн сахилга зөрчсөн бол Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас гадна дараах сахилгын шийтгэл ногдуулна:

42.1.1 албан тушаал, мэргэжлийн зэргийг 6 сар хүртэл хугацаагаар бууруулах;

42.1.2 төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх;

43 дугаар зүйл. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны нийгмийн баталгаа

43.1 Төмөр замын тээврийн байгууллагад 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэй төмөр замын тээврийн байгууллагаас тэтгэвэр тогтоолгосон бол 6-аас доошгүй сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авна.

43.2 Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор галт тэргээр жилд нэг удаагийн ирэх, очих замд үнэгүй зорчих.

43.3 Энэ хуулийн 43.1, 43.2-т заасан нийгмийн баталгаатай холбогдон гарах зардлыг төмөр замын тээврийн байгууллага хариуцна.

43.4 Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой, аюултай бүсэд ажиллаж, галт тэргэнд хяналт, шалгалт хийж байгаа төмөр замын техник хэрэгслийг турших ажилд оролцогч ажилтан нь ажил олгогчийн зардлаар гэнэтийн ослын даатгалд заавал хамрагдана.

43.5 Энэ хуулийн 43.4-т заасан гэнэтийн ослын даатгалд хамрагдаагүйгээс учирсан хохирлыг ажил олгогч хариуцна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн зохион байгуулалтын бусад асуудал

44 дүгээр зүйл. Төмөр замын тээвэр дэх даатгал

44.1 Төмөр замын объект, төмөр замаар тээвэрлэх ачааг хууль тогтоомжид заасан журмаар даатгалд хамруулж болно.

44.2 Зорчигч галт тэргээр явахдаа гэнэтийн ослын даатгалд хамрагдах үүрэгтэй.

45 дугаар зүйл. Төмөр замын тээвэрт хэрэглэх хэл

45.1 Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төмөр замын тээврийн байгууллага өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйл ажиллагаа, албан хэргийг төрийн албан ёсны хэлээр хөтлөн явуулна.

45.2 Төмөр замын өртөө, зөрлөг, буудал, бусад газарт зорчигч болон ачаа илгээгч, хүлээн авагчид шаардлагатай мэдээллийг төрийн албан ёсны хэлнээс гадна өөр хэлээр хүргэж болно.

АРАВДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

46 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

46.1 Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

46.1.1 төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, стандарт, норм, нормативыг зөрчсөн, төмөр замын тээврийн хяналтын Улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.2 төмөр замын осол, сүйрэл, гологдлоос сэргийлэх арга хэмжээг зохих ёсоор аваагүй, бол төмөр замын тээврийн байгууллага, нийтийн хэрэглээний болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.3 энэ хуулийн 46.1.1, 46.1.2 -т заасан зөрчлийг удаа дараа гаргасан, төмөр замын тээврийн аюулгүй байдлын журмыг ноцтой зөрчсөнөөс бусдын амь нас, эрүүд мэндэд хохирол учирсан, төмөр замын хэвийн үйл ажиллагааг удаан хугацаагаар алдагдуулсан сүйрэл гарахад хүргэсэн бол төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээг хүчингүй болгох, эсхүл хүчингүй болгохгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.4 төмөр замын аюулгүйн бүс, зурвас газар, аюултай бүсийн дэглэм зөрчсөн бол хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.5 төмөр замын аюултай бүсийн хамгаалалтыг хэрэгжүүлээгүй бол тээврийн үйл ажиллагаанд оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.6 төмөр замын аюултай бүсийн хамгаалалтын арга хэмжээг зохих ёсоор аваагүйгээс осол, гологдол гаргасан бол тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.7 энэ хууль болон Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж үндэслэлгүйгээр тариф тогтоож мөрдсөн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хууль бусаар олсон орлогыг хурааж улсын орлого болгох;

46.1.8 энэ хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тодорхойлсон журам зөрчиж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад их хэмжээий хохирол учруулсан тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.9 энэ хуулийн 27, 28, 29, 30 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч болон төмөр замын тээврийн үйлчилгээ, хөдөлгөөний аюулгүй байдал, стандарт, норм нормативын шаардлагатай холбоотой хууль тогтоомж зөрчсөн төмөр замын бус байгууллага, аж ахуйн нэгжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, тэдгээрийн буруутай албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.10 энэ хуулийн 46.1.9-д заасан зөрчлийг удаа дараа гаргасан, эсхүл ноцтой зөрчил гаргасан бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан бол тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, тэдгээрийн буруутай албан тушаалтан, ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

-----oOo-----

АЖЛЫН ХЭСЭГ